

**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2009 ОНЫ ШҮҮН  
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН  
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

2010 оны 01 дүгээр  
сарын 07-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар**

Анхан шатны шүүхүүд 2009 онд 10033 хүнд холбогдох 6668 эрүүгийн хэрэг хүлээн авч, 855 хүнд холбогдох 482 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 4 хүнд холбогдох 3 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, 400 хүнд холбогдох, 222 хэргийг шүүгдэгч, хохирогч эвлэрснээр, 407 хүнд холбогдох хэргийг цагаатгах тогтоолоор, 218 хүнд холбогдох 142 хэргийг Өршөөл үзүүлэх тухай хуульд зааснаар шүүгчийн захирамжаар тус тус хэрэгсэхгүй болгож 7513 хүнд холбогдох 5407 хэргийг таслан шийдвэрлэж, оны эцэст 636 холбогдогчтой 412 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 7,0 хувиар, ял шийтгүүлэгчид 11.6 хувиар буурчээ.

Анхан шатны шүүхээр 2009 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Эрүүгийн хэргийн тоо				Ял шийтгүүлэгчдийн тоо			
		Бүтэн жилд		Өсөлт, бууралт		Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2008 он	2009 он	тоо	хувь	2008 он	2009 он	тоо	хувь
1	Архангай	98	76	-22	-22.45	146	131	-15	-10.27
2	Баян-Өлгий	96	89	-7	-7.29	120	100	-20	-16.67
3	Баянхонгор	155	161	6	3.87	216	165	-51	-23.61
4	Булган	108	97	-11	-10.19	146	133	-13	-8.90
5	Говь-Алтай	69	45	-24	-34.78	107	63	-44	-41.12
6	Говьсүмбэр	38	34	-4	-10.53	41	34	-7	-17.07
7	Дархан-Уул	209	259	50	23.92	349	380	31	8.88
8	Дорнод	169	136	-33	-19.53	237	166	-71	-29.96
9	Дорноговь	222	208	-14	-6.31	311	285	-26	-8.36
10	Дундговь	88	71	-17	-19.32	130	104	-26	-20.00
11	Завхан	95	87	-8	-8.42	129	119	-10	-7.75
12	Орхон	196	167	-29	-14.80	284	259	-25	-8.80
13	Өвөрхангай	160	125	-35	-21.88	251	183	-68	-27.09
14	Өмнөговь	109	116	7	6.42	151	147	-4	-2.65
15	Сүхбаатар	143	105	-38	-26.57	158	117	-41	-25.95
16	Сэлэнгэ	358	338	-20	-5.59	560	540	-20	-3.57
17	Төв	222	181	-41	-18.47	305	232	-73	-23.93
18	Увс	166	166	0	0.00	267	246	-21	-7.87
19	Ховд	180	125	-55	-30.56	253	142	-111	-43.87
20	Хөвсгөл	174	124	-50	-28.74	261	154	-107	-41.00

21	Хэнтий	145	174	29	20.00	211	224	13	6.16
22	Нийслэл	2612	2523	-89	-3.41	3862	3589	-273	-7.07
	Дүн	5812	5407	-405	-6.97	8495	7513	-982	-11.56

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Нийслэл, Сэлэнгэ, Дорноговь, Баян-Өлгий, Завхан, Булган, Говьсүмбэр, Орхон, Төв, Дундговь, Дорнод, Өвөрхангай, Архангай, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд, Говь-Алтай аймагт 3,4 – 34,8 хувиар буурч, Баянхонгор, Өмнөговь, Хэнтий, Дархан-Уул аймагт 3,9 - 24,0 хувиар нэмэгджээ. Харин Увс аймаг өмнөх оны мөн үетэй адил байна.

Ял шийтгүүлэгчид Өмнөговь, Сэлэнгэ, Нийслэл, Завхан, Увс, Дорноговь, Орхон, Булган, Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дундговь, Баянхонгор, Төв, Сүхбаатар, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Говь-Алтай, Ховд аймагт 2,7 - 43,9 хувиар буурч, Хэнтий, Дархан-Уул аймагт 6,2 - 8,9 хувиар өссөн байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

Д/д	Хэргийн төрөл	Хэргийн тоо				Ял шийтгүүлэгчид			
		Бүтэн жил		Өсөлт, бууралт		Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2008 он	2009 он	тоо	хувь	2008 он	2009 он	тоо	хувь
1	Хүнийг санаатай алах	257	219	-38	-14.79	285	239	-46	-16.14
2	Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах	258	284	26	10.08	271	295	24	8.86
3	Бусдын эд хөрөнгийг хулгайлах	1590	1349	-241	-15.16	2641	2195	-446	-16.89
4	Танхайрах	713	746	33	4.63	1020	1060	40	3.92
5	Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	202	284	82	40.59	432	620	188	43.52
6	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	713	712	-1	-0.14	734	711	-23	-3.13
7	Албан тушаалын гэмт хэрэг	25	10	-15	-60.00	34	20	-14	-41.18
8	Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх	35	66	31	88.57	49	78	29	59.18

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 67,9 хувь, ял шийтгүүлэгчдийн 69,5 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 52,0, ял шийтгүүлэгчдийн 52,8 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 0,1, бусдыг санаатай алсан гэмт хэрэг 14,8, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 15,2, албан тушаалын гэмт хэрэг 60,0

хувиар буурсан бол, танхайрах гэмт хэрэг 4,6, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 10,1, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 40,6, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 88,6 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

Д/д	Үзүүлэлт	Бүтэн жил		Өсөлт, бууралт	
		2008 он	2009 он	Тоо	Хувиар
Ял шийтгүүлэгчид. Үүнээс:	Насанд хүрээгүй этгээд	547	386	-161	-29.43
	Эмэгтэйчүүд	799	656	-143	-17.90
	Гадаадын харъяат	43	26	-17	-39.53
	Урьд ял шийтгүүлсэн	1638	1637	-1	-0.06
	Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн	1578	1314	-264	-16.73
	Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн	2014	1610	-404	-20.06
	Ажил, сургуульгүй	5282	5047	-235	-4.45

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 19 тэрбум 440 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 483 хүний амь хохирч, 2461 хүний биед (хүнд, хүндэвтэр, хөнгөн) гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

Д/д	Төрөл	Бүтэн жил		Нийт ялын дотор эзлэх хувь	
		2008 он	2009 он	2008 он	2009 он
<i>Нийт ял шийтгүүлэгчид</i>		<b>8495</b>	<b>7513</b>		
1	Хорих ялаар бүгд: Үүнээс	<b>6150</b>	<b>5742</b>	<b>72.4</b>	<b>76.4</b>
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	3011	3074		
	б/ Тэнссэн	2517	2013		
	в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс:	555	305		
	а/Насанд хүрээгүй этгээд	447	226		
	б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг	108	79		
	г/ Өршөөл үзүүлсэн	67	350		
2	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн: Үүнээс	2242	1771		
	а/ Торгох ял	419	260		
	б/ Албадан ажил хийлгэх ял	534	337		
	в/ Баривчлах ял	1289	1099		
3	Бусад ял	<b>27</b>	<b>11</b>	<b>0.3</b>	<b>0.1</b>
4	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	<b>76</b>	<b>64</b>	<b>0.9</b>	<b>0.9</b>

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 76,4 хувьд хорих, 4,5 хувьд албадан ажил хийлгэх, 14,6 хувьд баривчлах, 0,1 хувьд бусад ял оногдуулж, насанд хүрээгүй 64 этгээдэд (0,9 хувь)

хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авчээ. Мөн 3,5 хувь буюу 260 хүнийг 846,8 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

3074 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 53,5 хувь нь болж байна.

Хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгүүлсэн хүн 4173 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 55,5 хувийг эзэлж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 360 хүнд хэрэглэж 206,5 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 464 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 3074 хүний 70,1 хувийг жирийн, 27,9 хувийг чанга, 1,8 хувийг онцгой, 0,2 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2216 хэрэг хүлээн авснаас 2110 хэргийг хянан шийдвэрлэж, 1089 буюу 51,6 хувьд нь захирамж, тогтоолыг хэвээр үлдээж, 554 буюу 26,3 хувьд нь захирамж, тогтоолд өөрчлөлт оруулж, 467 буюу 22,1 хувьд нь захирамж, тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 65 хэргийн үлдэгдэлтэй гарав. 41 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү +/-,-/-
Хянан шийдвэрлэсэн бүгд	2088	2110			
Хэвээр үлдээсэн	1127	1089	54.0	51.6	- 2.4
Өөрчлөлт оруулсан	468	554	22.4	26.3	+ 3.9
Хүчингүй болгосон	493	467	23.6	22.1	- 1.5
Үлдэгдэл	82	65			

Давж заалдах шатны шүүх 1021 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 48,4 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 638 хэрэг хүлээн авснаас, 497 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 132 хэргийг хянаж, хариу өгсөн ба оны эцэст 9 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 232 буюу 46,6 хувийг хэвээр үлдээж, 122 буюу 24,6 хувийг өөрчилж, 143 буюу 28,8 хувийг хүчингүй болгожээ. Мөн Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар 12 хэргийг хянан шийдвэрлэжээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү +/-,-/-
Хүлээн авсан хэрэг	689	638			
Хянан шийдвэрлэсэн бүгд	668	629			
Хянаад хүргүүлсэн	172	132			

Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:		<b>496</b>	<b>497</b>			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		470	485			
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн		26	12			
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	270	232	54.4	46,6	-7,8
	Өөрчлөлт оруулсан	106	122	21.4	24,6	+3,2
	Хүчингүй болгосон	120	143	24.2	28,8	+4,6
Үлдэгдэл		21	9			

Хяналтын шатны шүүх 265 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 53,3 хувийг эзэлж байна.

### **Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар**

Анхан шатны шүүхүүд 48204 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 8324 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд 35822 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 7342 хэргээр буюу 25,8 хувиар өссөн байна. Оны эцэст 4058 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 35822 хэргийн 15322 буюу 42,8 хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 20500 буюу 57,2 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2009 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		өсөлт, бууралт	
		2008 он	2009 он	тоо	хувь
1	Архангай	626	949	323	51.60
2	Баян-Өлгий	707	1048	341	48.23
3	Баянхонгор	833	1052	219	26.29
4	Булган	617	846	229	37.12
5	Говь-Алтай	520	782	262	50.38
6	Говьсүмбэр	311	496	185	59.49
7	Дархан-Уул	1341	1958	617	46.01
8	Дорнод	1164	1134	-30	-2.58
9	Дорноговь	691	1082	391	56.58
10	Дундговь	560	529	-31	-5.54
11	Завхан	874	954	80	9.15
12	Орхон	956	1470	514	53.77
13	Өвөрхангай	1635	1565	-70	-4.28

14	Өмнөговь	483	594	111	22.98
15	Сүхбаатар	483	848	365	75.57
16	Сэлэнгэ	1292	1676	384	29.72
17	Төв	1043	1307	264	25.31
18	Увс	541	672	131	24.21
19	Ховд	875	1053	178	20.34
20	Хөвсгөл	1383	1717	334	24.15
21	Хэнтий	672	1826	1154	1.7 дахин
22	Нийслэл	10873	12264	1391	12.79
	Дүн	28480	35822	7342	25.78

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Завхан, Нийслэл, Ховд, Өмнөговь, Хөвсгөл, Увс, Төв, Баянхонгор, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Баян-Өлгий, Говь-Алтай, Архангай, Орхон, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий аймагт 9,2 хувиас 1,7 дахин нэмэгджээ. Харин Дорнод, Өвөрхангай, Дундговь аймагт 2,6 - 5,5 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь		Зөрүү /+/,/-/
	2008 он	2009 он	2008 он	2009 он	
<b>Нийт иргэний хэрэг</b>	<b>28480</b>	<b>35822</b>			
Иргэний эрх зүйн маргаан	9480	15508	33.3	43,3	+ 10.0
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар	12313	11137	43.2	31,1	- 12.1
Гэр бүлийн эрх зүйн маргаан	3629	4294	12.7	12,0	- 0.7
Хөдөлмөрийн эрх зүйн маргаан	682	967	2.4	2,7	+ 0.3
Бусад эрх зүйн маргаан: Үүнээс:	2376	3916	8.4	10,9	+ 2.5
Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар	10	63			
Дампуурлын тухай хуулиар	17	1			
Компаний тухай хуулиар	7	13			
Нийгмийн даатгалын багц хуулиар	111	401			
Патентийн тухай хуулиар	5	2			
Зохиогчийн эрхийн тухай хуулиар	1	2			
Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар	1	1			
Төрийн албаны тухай хуулиар	2	10			
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар	160	123			
Бусад хуулиар	2062	3300			

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 43,3, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 31,1, гэр бүлийн эрх зүйн маргаан 12,0, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2,7 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 2137 хэрэг хүлээн авснаас 2006 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 965 буюу 48,1 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 597 буюу 29,8 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 444 буюу 22,1 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 81 хэргийн үлдэгдэлтэй гарав. 50 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү +/-,-/-
Хянан шийдвэрлэсэн бүгд	<b>1516</b>	<b>2006</b>			
Хэвээр үлдээсэн	600	965	39,5	48,1	+8,6
Өөрчлөлт оруулсан	515	597	34,0	29,8	-4,2
Хүчингүй болгосон	401	444	26,5	22,1	-4,4
Үлдэгдэл	117	81			

Давж заалдах шатны шүүх 1041 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 51,9 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 1060 хэрэг хүлээн авч, 192-г хянан хариу өгч, 803 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байна. Үүнээс шийдвэр, магадлалын 467 буюу 58.2 хувийг хэвээр үлдээж, 221 буюу 27,5 хувийг өөрчилж, 115 буюу 14,3 хувийг нь хүчингүй болгож, 65 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хянан шийдвэрлэсэн нийт 803 хэргээс 1 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 56 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ.

	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь			
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү +/-,-/-	
Хүлээн авсан хэрэг	<b>809</b>	<b>1060</b>				
Хянаад хариу өгсөн хэрэг	171	192				
Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс:	<b>620</b>	<b>803</b>				
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	589	746				
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн	3	1				
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн	28	56				
Үүнээс:	Хэвээр үлдээсэн	362	467	58,4	58,2	-0,2
	Өөрчлөлт оруулсан	164	221	26,5	27,5	+1,0
	Хүчингүй болгосон	94	115	15,1	14,3	-0,8
Үлдэгдэл	18	65				

Хяналтын шатны шүүх 336 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 41,8 хувийг эзэлж байна.

### **Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар**

Захиргааны хэргийн шүүхүүд 2009 онд 1739 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 422 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар

урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 1074 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 248 хэргээр буюу 30,0 хувиар өсчээ.

Оны эцэст 243 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 38 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 45 хэргийн шүүх хуралдааныг хойшуулж, 160 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2009 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

Д/д	Шүүх	Бүтэн жилд		Өсөлт, бууралт	
		2008 он	2009 он	тоо	хувь
1	Архангай	24	25	1	4.17
2	Баян-Өлгий	47	69	22	46.81
3	Баянхонгор	15	21	6	40.00
4	Булган	13	30	17	1.3 дахин
5	Говь-Алтай	20	14	-6	-30.00
6	Говьсүмбэр	15	15	0	0.00
7	Дархан-Уул	19	29	10	52.63
8	Дорнод	31	20	-11	-35.48
9	Дорноговь	7	22	15	2.1 дахин
10	Дундговь	13	10	-3	-23.08
11	Завхан	3	37	34	11.3 дахин
12	Орхон	43	65	22	51.16
13	Өвөрхангай	28	52	24	85.71
14	Өмнөговь	15	10	-5	-33.33
15	Сүхбаатар	32	40	8	25.00
16	Сэлэнгэ	16	26	10	62.50
17	Төв	31	29	-2	-6.45
18	Увс	30	12	-18	-60.00
19	Ховд	15	28	13	86.67
20	Хөвсгөл	28	50	22	78.57
21	Хэнтий	17	20	3	17.65
22	Нийслэл	364	450	86	23.63
	Дүн	826	1074	248	30.02

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг Архангай, Хэнтий, Нийслэл, Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай, Ховд, Булган, Завхан, Дорноговь аймагт 4,2 хувиас 11,3 дахин нэмэгдэж, Төв, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь, Дорнод, Увс аймагт 6,5 – 60,0 хувиар буурчээ. Харин Говьсүмбэр аймаг өмнөх оны мөн үетэй адил байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл,

Маргааны төрөл	Бүтэн жилд		Нийт хэрэгт эзлэх хувь	
	2008 он	2009 он	2008 он	2009 он
<b>Нийт захиргааны хэрэг</b>	<b>826</b>	<b>1074</b>		



Сонгуультай холбоотой маргаан	116	69	14,0	6,4
Төрийн албаны тухай хуулиар	100	197	12,1	18,3
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан	10	9	1,2	0,9
Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан	61	71	7,4	6,6
Газрын маргаан	163	228	19,7	21,2
Ашигт малтмалтай холбоотой маргаан	62	61	7,6	5,7
Татварын маргаан	32	87	3,9	8,1
Тендерийн маргаан	20	34	2,4	3,2
Бусад маргаан	262	318	31,7	29,6

байдалтай байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатаар 521 хэрэг хүлээн авч 476 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 4 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэж, үүнээс 64,9 хувь буюу 309 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 9,9 хувь буюу 47 шийдвэрт өөрчлөлт оруулж, 25,2 хувь буюу 120 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 37 хэргийг үлдэгдэлтэй гарчээ. 8 хэргийг хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзсан байна.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү /+/, -/
	<b>Хүлээн авсан хэрэг</b>	<b>400</b>	<b>521</b>		
Хянаад хариу өгсөн хэрэг	9	8			
<b>Нийт шийдвэрлэсэн хэрэг</b>	<b>370</b>	<b>476</b>			
Үүнээс:					
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг	368	472			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан	2	4			
Үүнээс:					
Хэвээр үлдээсэн	194	309	52,4	64,9	+12,5
Өөрчлөлт оруулсан	66	47	17,8	9,9	-7,9
Хүчингүй болгосон	110	120	29,8	25,2	-4,6
Үлдэгдэл	21	37			

Хяналтын шатны шүүх 338 хэрэг хүлээн авснаас 241 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 55 хэргийг хянан хариу өгч, одоо 42 хэргийг үлдэгдэлтэй байна. Хянан хэлэлцсэн 241 хэргээс 5 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн 241 хэргийн 67,2 хувь буюу 162 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 15,4 хувь буюу 37 шийдвэр, магадлалыг өөрчилж, 17,4 хувь буюу 42 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

Үзүүлэлт	Бүтэн жилд		Хянагдсан хэрэгт эзлэх хувь		
	2008 он	2009 он	2008 он	2009 он	зөрүү /+/, -/
<b>Хүлээн авсан хэрэг</b>	<b>260</b>	<b>338</b>			
Хянаад хариу өгсөн хэрэг	48	55			

Нийт шийдвэрлэсэн хэрэг. Үүнээс:		<b>197</b>	<b>241</b>			
Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг		192	236			
Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн		1	0			
Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан		4	5			
Үүнээс	Хэвээр үлдээсэн	121	162	61.4	67.2	+ 5.8
	Өөрчлөлт оруулсан	41	37	20.8	15.4	- 5.4
	Хүчингүй болгосон	35	42	17.8	17.4	- 0.4
	Үлдэгдэл	15	42			

### **Дөрөв. Бусад асуудлаар**

Анхан шатны шүүхүүд бүгд 12688 (-2225) хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 682 (-582) хүнийг 10,6 (-8,7) сая төгрөгөөр торгож, 12006 (-1643) хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 191 (-72) шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 134 буюу 70,2 хувьд хэвээр үлдээж, 43 буюу 22,5 хувьд өөрчлөлт оруулж, 14 буюу 7,3 хувийг хүчингүй болгожээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 1459 (-1213) материалыг хянан хэлэлцэж, 22 (-12) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 825 (+317) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 40 (-183) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 572 (-838) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 1055 (-99) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 994 (-78) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 61 (-21) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2968 (+89) хүнийг сэжигтнээр, 3187 (+145) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 328 (+35) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 2 тэрбум 657 (+743) сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 2 тэрбум 49 (+518,3) сая төгрөг, давж заалдах шатны шүүх 444,2 (+120,1) сая төгрөг, хяналтын шатны шүүх 164,4 (+102,8) сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхээс 526,6 (+149,5) сая төгрөг, давж заалдах шатны шүүхээс 243,9 (+163.6) сая төгрөг, хяналтын шатны шүүхээс 17,6 (-9,3) сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 73583 (+5847) хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6256 (-78), иргэний 44146 (+8950), захиргааны 1496 (+243) хэрэг, 12688 (-2225) захиргааны зөрчил, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 1459 (-1213) хүсэлт, 7538 (-170) хүнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцжээ.

Ерөнхий харъяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 245, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 356 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 17, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар 85 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 2110, иргэний 2006, захиргааны зөрчлийн 191 бүгд 4307 хэрэг хянан шийдвэрлэжээ. Аймгийн шүүхийн нэг шүүгч дунджаар 28, нийслэлийн шүүхийн нэг шүүгч дунджаар 116 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 803, эрүүгийн 497, захиргааны 241, давж заалдах журмаар 476 нийтдээ 2017 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг 161, эрүүгийн хэрэг 99, захиргааны 120 хэрэг ногдож байна.

## ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ